



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ НААДАМ-2017”
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.5, Нийслэлийн Засаг даргын А/475 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголчуудын уламжлалт соёлыг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Дээлтэй Монгол наадам-2017” арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Дээлтэй Монгол наадам-2017” арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

3. “Дээлтэй Монгол Наадам-2017” арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах 20 000 000 /хорин сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. “Дээлтэй Монгол наадам-2017” арга хэмжээний тайланг 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Жавхлан/-д даалгасугай.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ



1150500212

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 06 сарын 27
өдрийн 15 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|-----------------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга Д.Жавхлан |
| Ажлын хэсгийн гишүүд: | Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн Б.Тулгаа |
| | Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн Б.Ербахыт |
| | Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн Н.Алтанзаяа |
| | Тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн Э.Мөнхзул |
| Нарийн бичгийн дарга: | Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаа |

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 06 сарын 27 өдрийн А/55 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ НААДАМ-2017” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**


2017.06.27


Улаанбаатар хот

| Д/д | Хариуцах ажил | Хугацаа | Хариуцах мэргэжилтэн |
|-----|--|-------------|-------------------------------------|
| 1 | Захирамж, тушаал, удирдамж, төсвийг батлуулж, ажлын хэсгийг байгуулах | 06.15 | Ш.Ундармаа |
| 2 | Ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах, байгууллага аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах, тайлан, гэрээ дүгнэсэн актыг хийх | 06.20-07.08 | Ш.Ундармаа |
| 3 | Урлагийн болон олон нийтийг хамарсан тоглолт, тэмцээнийг зохион байгуулах | 06.20-07.08 | Б.Тулгаа Ш.Ундармаа Б.Ербахыт |
| 4 | Арга хэмжээний тайз, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, талбайн цахилгааны эх үүсвэрийг хариуцах /гарч болзошгүй эрсдэлийг тооцох/ | 07.09.07.10 | Б.Ербахыт Б.Тулгаа |
| 5 | Найруулагчтай гэрээ байгуулах, арга хэмжээний хөтөлбөрийг батлуулах, хяналт тавих | 07.01 | Б.Тулгаа Ш.Ундармаа |
| 6 | Арга хэмжээний маркетинг сурталчилгааг хариуцах /социал, цахим хуудасны идэвхжүүлэлт, хэвлэмэл хуудас, анонс, ТВ шторк, өргөмжлөл, хэвлэлийн мэдээ мэдээлэл, шууд дамжуулалт, хэвлэлийн бага хурал зохион байгуулах гэх мэт/ | 06.20-07.10 | /МСХ/ Д.Жавхлан Ш.Ундармаа |
| 7 | Дүүргүүдтэй холбогдон парадын зохион байгуулалтыг хариуцах. Дүүргүүд, байгууллага аж ахуйн нэгжүүдийн танилцуулга видео, парад оролцох байгууллага, дүүргүүдийн бүртгэлийг нэгтгэх | 06.25.07.10 | Н.Алтанзаяа |
| 8 | Худалдаа үйлчилгээний газруудыг сонгох, бүртгэх, асарт хуваарилах ажлыг хариуцах | 06.20-07.10 | Э.Мөнхзул |
| 9 | Замын хөдөлгөөний зохицуулалт, хэв журмыг сахиулах, яаралтай тусламжийн баг гаргах, парад явах замын хамгаалалтын зурвасыг чөлөөлөх, хамгаалалтын хашлага байрлуулах | 06.25-07.10 | Ш.Ундармаа М.Баасандорж |
| 10 | Байгууллагуудтай хамтран ажиллах саналыг хүргүүлж хамтран ажиллах, шагналын санг хариуцах | 06.14-07.10 | Б.Тулгаа Б.Жавхлан |
| 11 | Талбайн схем зураг, парад явах зам, дүүргүүдийн байрлах газрын зураглал гаргах, “Дээлтэй Монгол наадам”-ын төв тайзны дэлгэцэд гаргах видео, танилцуулгыг бэлтгэх | 06.20-07.10 | Б.Ербахыт |
| 12 | “Дээлтэй Монгол наадам-2017” арга хэмжээний тохижилтыг хариуцах | 07.09-07.10 | Б.Тулгаа Б.Ербахыт Ш.Ундармаа |
| 13 | Үндэсний хувцасны парадын бүртгэлийг хариуцах | 07.10 | Г.Азжаргал |

| | | | |
|----|---|-------------|------------------|
| 14 | Аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран жуулчдыг парадад оролцуулах, Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, төлөөлөгчийн газарт урилга хүргүүлэх | 06.25-07.07 | Б.Жавхлан МСХ |
| 15 | Шүүгчдийн баг, шагналыг хариуцах | 06.25.07.10 | Г.Азжаргал |

--ooOoo--

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА
 Д.ГАНБОЛД

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
 Ш.УНДАРМАА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 06 сарын 07 өдрийн А.53 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ НААДАМ-2017" АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017.06.27

Улаанбаатар хот

| № | Зардлын зүйл | Тоо хэмжээ | Нэгж зардал | Нийт зардал |
|-----------------|--|------------------|-------------|-------------------|
| 1 | Сурталчилгааны шторк хийлгэх | 1 багц 30 сек | 1 500 000 | 1 500 000 |
| 2 | Талбайн анонс хэвлүүлэх, тогтоох | 11*11м | 5500 | 665 500 |
| 3 | Самбарын түрээсийн төлбөр | 3 хоног | 275 000 | 825 000 |
| 4 | Өргөмжлөл хийлгэх /каллиграф бичлэг/ | багц | 500 000 | 500 000 |
| 5 | Хөтлөгчийн хөлс | 2 | 722 500 | 1 455 000 |
| 6 | Урлагийн тоглолт зохион байгуулах | багц | 4 667 000 | 4 667 000 |
| 7 | Урлаг, загварынхныг тээвэрлэх автобус түрээслэх зардал | 4 удаа | 100 000 | 400 000 |
| 8 | Цахилгааны эх үүсвэр татах зардал | багц | 300 000 | 300 000 |
| 9 | Сайн дурын ажилтнуудын ажлын хөлс | 10 | 20 000 | 200 000 |
| 10 | Найруулагчийн төлбөр | багц | 1 069 500 | 1 069 500 |
| 11 | Дээл дэлгэх ажлыг зохион байгуулах зардал | багц | 800 000 | 800 000 |
| 12 | Шагналын сан / шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг оролцогчдын шагнал нийт 11 төрөл/ | багц | 4 728 000 | 4 728 000 |
| 13 | Шүүгчдын ажлын төлбөр | 2 хүн | 120 000 | 240 000 |
| 14 | Загварын үзүүлбэрийг зохион байгуулах | 2 агентлаг | 1 000 000 | 2 000 000 |
| 15 | Гэр түрээслэх | 1ш /казах гэр/ | 400 000 | 400 000 |
| | | 1ш /монгол гэр/ | 250 000 | 250 000 |
| Нийт дүн | | | | 20 000 000 |

--ooOoo--

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

ТӨСӨВ ЗОХИОСОН:
СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА